

Юүчо банктай харилцаж буй гадаадын улсын иргэн та

■ Данс нээх үе, хаяг болон овог нэрээ солих, хувийн тамга солих үед оршин суугчийн үнэмлэхээ үзүүлнэ үү.

Иргэншил, оршин суух статус, оршин суух хугацаа гэх мэтийг баталгаажуулахын тулд оршин суух үнэмлэхээ үзүүлнэ үү.

* Хэрэв оршин суух үнэмлэхээ сунгасан бол банктай харилцаж байхдаа мэдэгдэнэ үү.

* Хэрэв дипломат албаны ажилтан бөгөөд оршин суух үнэмлэх олгогдоогүй бол шаардлагагүй.

■ Данс нээх хүсэлт өгсөн өдрөөс хойш 3 сарын дотор оршин суух хугацаа дуусч байвал оршин суух хугацааны сунгалтыг хийж дууссаны дараа данс нээлгэх хүсэлт гаргана уу.

Данс нээх хүсэлт өгсөн өдрөөс хойш 3 сарын дотор оршин суух хугацаа дуусч байвал данс нээх боломжгүй.

Та Япон улсад үргэлжлүүлэн оршин суух төлөвлөгөөтэй бол оршин суух хугацааны сунгалт хийсний дараа буюу оршин суух хугацаа сунгагдсан шинэ оршин суугчийн үнэмлэхийг авч ирэн, данс нээх хүсэлтийг гаргана уу.

* Япон улсад ирэх үед тогтоосон оршин суух хугацаа нь 3 сараас дотогш бөгөөд, оршин суугчийн үнэмлэх олгогдоогүй хүнд Юүчо банк болон шуудангийн газар нь данс нээж өгөх боломжгүй.

* Оршин суух статус, оршин суух хугацааны сунгалт нь хараахан дуусаагүй бол сунгалт хийлгэж дууссаны дараа шинэ оршин суугчийн үнэмлэхээ авч ирнэ үү.

■ Оюутны үнэмлэх, ажилтны үнэмлэхээ үзүүлнэ үү.

Оршин суух статус нь "Гадаад оюутан", "Ур чадварын дадлагажигч" байгаа хүн данс нээх үед ажил сургуулийн харьяаллын бодит байдал, ажлын нөхцөл байдал зэргийг шалгах үүднээс оршин суугчийн үнэмлэхийн хамт оюутны үнэмлэх эсвэл ажилтны үнэмлэхийг үзүүлнэ үү.

* Бид таны сургууль эсвэл ажлын газар уруу ажил сургуулийн харьяаллыг баталгаажуулах зорилгоор холбогдох тохиолдол байдаг.

■ Данс бүрэн нээгдэх хүртэл танд хугацаа зарцуулах тохиолдол байдаг.

Гадаад улсын иргэн нь данс нээлгэх хүсэлт гаргахад холбогдох хууль тогтоомжийн дагуу төрөл бүрийн шалгалт хийж, цаг хугацаа шаардагддаг тул хүсэлт хүлээн авсан тухайн өдөр данс нээж амжилгүй, дараа нь хадгаламжийн дэвтрийг таны гэрт шуудангаар илгээх тохиолдол байдаг. Мөн, зарим тохиолдолд бид данс нээхээс татгалзаж болохыг анхаарна уу.

■ Бусад анхаарах зүйлс

• Оршин суух үнэмлэхээ сунгасан бол шинэчилсэн үнэмлэхээ авчирч нэн даруй харилцах цонхонд мэдэгдэнэ үү. Хэрэв шинэ үнэмлэхээ мэдэгдээгүй бол гүйлгээг түр хугацаагаар хязгаарлах тохиолдол байдаг.

• Бидэнд үзүүлсэн нотлох бичиг баримтыг бид хуулбарлан авах болно.

• Япон улсын иргэний бүртгэл дахь Үндсэн оршин суугч бус хүн нь Үндсэн оршин суугч болж өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй харилцах цонхонд ирж мэдэгдэнэ үү.

• Эх орондоо буцах болон Японоос өөр улс уруу нүүх тохиолдолд дансны гэрээгээ цуцлах ажиллагааг хийнэ үү.

• Бусдад ашиглуулах зорилгоор данс (хадгаламжийн дэвтэр, бэлэн мөнгөний карт) дамжуулах болон худалдах худалдан авах нь гэмт хэрэг юм. Хэзээ ч бүү хийгээрэй.